



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20¹⁷ он ¹⁰
сарын ¹⁷ өдөр

Дугаар 3Г-1/140

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
М.ЭНХБОЛД ТАНАА

Монгол Улсын Засгийн газрын
гишүүдийг томилуулах тухай

Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасныг үндэслэн дараах хүмүүсийг дор дурдсан албан тушаалд томилуулах асуудлыг Монгол Улсын Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна:

1. Өлзийсайханы Энхтүвшинг Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайдын;
2. Гомбожавын Занданшатарыг Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын;
3. Намсрайн Цэрэнбатыг Засгийн газрын гишүүн-Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын;
4. Нямаагийн Энхболдыг Засгийн газрын гишүүн-Батлан хамгаалахын сайдын;
5. Дамдины Цогтбаатарыг Засгийн газрын гишүүн-Гадаад харилцааны сайдын;
6. Чимэдийн Хүрэлбаатарыг Засгийн газрын гишүүн-Сангийн сайдын;
7. Содномын Чинзоригийг Засгийн газрын гишүүн-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын;
8. Цэндийн Нямдоржийг Засгийн газрын гишүүн-Хууль зүй, дотоод хэргийн сайдын;
9. Хавдисламын Баделханыг Засгийн газрын гишүүн-Барилга, хот байгуулалтын сайдын;
10. Цэдэнбалын Цогзолмааг Засгийн газрын гишүүн-Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын;

000873

11.Жадамбын Бат-Эрдэнийг Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн хөгжлийн сайдын;

12.Долгорсүрэнгийн Сумъяабазарыг Засгийн газрын гишүүн-Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын;

13.Батжаргалын Батзоригийг Засгийн газрын гишүүн-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын;

14.Цэрэнпилийн Даваасүрэнг Засгийн газрын гишүүн-Эрчим хүчний сайдын;

15.Даваажанцангийн Сарангэрэлийг Засгийн газрын гишүүн-Эрүүл мэндийн сайдын.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Монгол Улсын Ерөнхий сайд



У ХҮВЭЛСҮХ

ТАНИЛЦУУЛГА

Улсын Их Хурлын 2017 оны 10 дугаар сарын 4-ны өдрийн 56 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхий сайдыг шинээр томилсон бөгөөд Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37.5-д “Ерөнхий сайд томилогдсоноосоо хойш 14 хоногийн дотор Засгийн газрын гишүүдийг томилуулах саналаа Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ” гэж заасан.

Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д “Ерөнхий сайд Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, Засгийн газрын гишүүнийг томилох, албан тушаалаас чөлөөлөх, огцруулах тухай саналаа Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ” гэж заасныг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр доор нэр дурдсан хүмүүсийг Монгол Улсын Засгийн газрын гишүүнээр томилуулах саналтай байна. Үүнд:

1.Өлзийсайханы Энхтүвшинг Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайдын;

2.Гомбожавын Занданшатарыг Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын;

3.Намсрайн Цэрэнбатыг Засгийн газрын гишүүн-Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын;

4.Нямаагийн Энхболдыг Засгийн газрын гишүүн-Батлан хамгаалахын сайдын;

5.Дамдины Цогтбаатарыг Засгийн газрын гишүүн-Гадаад харилцааны сайдын;

6.Чимэдийн Хүрэлбаатарыг Засгийн газрын гишүүн-Сангийн сайдын;

7.Содномын Чинзоригийг Засгийн газрын гишүүн-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын;

8.Цэндийн Нямдоржийг Засгийн газрын гишүүн-Хууль зүй, дотоод хэргийн сайдын;

9.Хавдисламын Баделханыг Засгийн газрын гишүүн-Барилга, хот байгуулалтын сайдын;

10.Цэдэнбалын Цогзолмааг Засгийн газрын гишүүн-Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын;

11.Жадамбын Бат-Эрдэнийг Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн хөгжлийн сайдын;

12.Долгорсүрэнгийн Сумъяабазарыг Засгийн газрын гишүүн-Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын;

13.Батжаргалын Батзоригийг Засгийн газрын гишүүн-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын;

14.Цэрэнпилийн Даваасүрэнг Засгийн газрын гишүүн-Эрчим хүчний сайдын;

15.Даваажанцангийн Сарангэрэлийг Засгийн газрын гишүүн-Эрүүл мэндийн сайдын.

Дээр дурдсан хүмүүсийг Монгол Улсын Засгийн газрын гишүүнд нэр дэвшүүлэхдээ тэдний улс төрийн болон тухайн салбартаа ажиллаж хуримтлуулсан туршлага, удирдан зохион байгуулах чадвар, хариуцлагатай, ажил хэрэгч чанарыг нь үндэслэсэн бөгөөд цаашид бүрэн эрхийнхээ хугацаанд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтуудыг биелүүлэхийн төлөө бүхий л мэдлэг, чадвар, нөөц бололцоогоо дайчлан танхимын зарчмаар хамтран ажиллах чадвартай гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын 2017 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн 55 дугаар тогтоолоор Засгийн газрыг огцруулж, шинээр Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайдыг томилогдтол үүрэгт ажлаа гүйцэтгэж байхыг Засгийн газрын гишүүдэд даалгасан.

Иймд Монгол Улсын Засгийн газрын гишүүдийг томилуулах саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх гэж байгаатай холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн "Монгол Улсын Засгийн газрын гишүүдийг үүрэгт ажлаас чөлөөлөх тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг мөн боловсрууллаа.

---000---